



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/Н8

Булган сум

Техникийн хяналтын явуулын төвөөр үзлэг хийх, авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйлчилгээ үзүүлэх, татвар, төлбөр, хураах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.10, Авто тээврийн тухай хуулийн 7.1.1, 17 дугаар зүйлийн 17.1, 19 дүгээр зүйлийн 19.2.1, 21 дүгээр зүйлийн 21.1.2, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Татварын Ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг явуулын төвөөр зохион байгуулах, авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх, хяналт хэрэгжүүлэх, албан татвар, төлбөр хураамж хураах ажлын удирдамжийг 1 дүгээр, сумдад ажиллах техникийн хяналтын үзлэгийн хуваарь, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн хэмжээнд авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг жилийн турш холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу чанартай зохион байгуулан ажиллахыг Авто тээврийн төвийн дарга (Ж.Батзориг)-д, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийг хууль тогтоомжид заасан хугацаанд хурааж улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллахыг Татварын хэлтсийн дарга (Д.Лхагвасүрэн)-д, техникийн хяналтын үзлэг болон тээврийн хэрэгслийн бүртгэлжүүлэх, татвар, даатгалын үйлчилгээ үзүүлэх ажлыг нэг цэгийн үйлчилгээний хэлбэрт оруулж батлагдсан хуваарийн дагуу чанартай зохион байгуулах, тээврийн хэрэгслийг бүрэн хамруулан ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6323010100

3. Техникийн үзлэг хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд техникийн хяналтад ороогүй, улсын дугаар, гэрчилгээ аваагүй (мотоцикль), авто тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, өөрчлөлт хийгдээгүй, албан татвар, агаарын бохирдлын төлбөр төлөөгүй, албан журмын даатгалд хамруулаагүй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээг авч хяналт шалгалтыг эрчимжүүлэн ажиллахыг Авто тээврийн төвийн дарга (Ж.Батзориг), Цагдаагийн газрын дарга (хурандаа Л.Ганбаатар) нарт тус тус чиглэл болгосугай.

4. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийг хуульд заасан хугацаанд хураах ажлын явцыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилж мэдээлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга (Г.Алтанцэцэг), Татварын хэлтсийн дарга (Д.Лхагвасүрэн), Авто тээврийн төвийн дарга (Ж.Батзориг)-д нарт хариуцуулсугай.

5. Техникийн хяналтын үзлэг, татвар, төлбөр хураалтын ажлыг заасан хугацаанд бүрэн хамруулаагүй тохиолдолд тухайн суманд дахин зохион байгуулж, гарах зардлыг хариуцан ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

6. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д даалгасугай.

7. Техникийн хяналтын явуулын болон суурин үзлэгийн төвийн багаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, үзлэгийн чанар байдалд хяналт тавьж ажиллахыг Авто тээврийн төвийн дарга (Ж.Батзориг)-д даалгасугай.

8. Авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэг, татвар, төлбөр хураалтын талаар зохион байгуулсан ажлын дүн, мэдээг Авто тээврийн төв сум бүрээр нэгтгэн тайланг 2023 оны 12 дугаар сарын 05-ны дотор аймгийн Засаг даргад тайлагнахыг Авто тээврийн төвийн дарга (Ж.Батзориг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар
сарын 15-ны өдрийн 1/118 захирамжийн
Нэгдүгээр хавсралт

**АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН
ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ, БҮРТГЭЛ, АЛБАН ТАТВАР, ХУРААМЖ ХУРААХ АЖЛЫН
УДИРДАМЖ**

Ажлын зорилго

Булган аймгийн нутаг дэвсгэрт авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, албан татвар, төлбөр хураах ажлыг холбогдох хууль, дүрэм, стандартын дагуу зохион байгуулах, замын хөдөлгөөнд оролцогчдын хариуцлага, соёлыг дээшлүүлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

Техникийн хяналтын үзлэг явагдах хугацаа

Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын явуулын төвөөр хийгдэх үзлэг, татвар, төлбөр хураах ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 21-ний өдрийг хүртэл зохион байгуулан явуулна.

Техникийн хяналтын үзлэг хийх үе шат, гүйцэтгэх ажил

1. Булган аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн авто тээврийн хэрэгслүүдийг хавсралтад заасан хуваарийн дагуу техникийн хяналтын үзлэгт бүрэн хамруулах.

2. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр төлсөн, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах.

3. Сумын Засаг даргын захирамжаар комисс томилж тус суманд ажиллах хуваарь, удирдамжид заагдсан ажил үйлчилгээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, үзлэгийн инженер, техникч, бүртгэлийн ажилтныг суманд ажиллах хугацаанд орон байраар үнэ төлбөргүй хангах, техникийн хяналтын үзлэгийн хуваарь, татвар төлбөр, хураамжийн талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, техникийн хяналтын үзлэг явуулах зогсоол талбайг цахилгаан хангамжтай газар бэлдэж ажиллах нөхцөлийг хангах, нэг цэгт төвлөрүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах.

4.Эзэмшигчийн өөр аймаг, сумын харьяалалд байгаа болон гаднын дугаартай, улсын дугаар давхардсан авто тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулах, орон нутгийн индекс бүхий улсын дугаар олгох, замын хөдөлгөөнд оролцож байгаа мотоциклыг улсын дугаарлуулж бүртгэлд хамруулах, авто үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэний нэгдсэн судалгааг шинэчлэн гаргах, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэдийг нөхөрлөл, хоршоолол байгуулан ажиллуулах, иргэн хуулийн этгээдийн ашиглагдахгүй, сүүлийн 5-н жилд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй болон авто тээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн татвар төлөгдөөгүй тээврийн хэрэгслүүдийн судалгааг гаргаж, тоо бүртгэлээс хасах зэрэг ажлыг зохион байгуулах.

5.Багийн Засаг дарга нар техникийн хяналтын үзлэгт хамрагдаж буй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн бүртгэлийг тулган, үзлэгт хамруулах арга хэмжээг авч дэмжлэг туслалцааг үзүүлэх.

6.Авто тээврийн хэрэгслийг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу тэнцсэн тохиолдолд гэрчилгээнд тэмдэглэгээ хийж, гарын үсгээр баталгаажуулан хяналтын гэрчилгээ олгох,

7.Авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулахгүйгээр техникийн хяналтын үзлэгт тэнцүүлсэн дүгнэлт гаргахгүй байх,

8.Баруун гар талдаа жолооны хүрдтэй автомашины их гэрлийн тусгалыг өөрчлөх бэлдэц суурилуулах болон таних тэмдэг наалт наах,

9.Техникийн хяналтын үзлэгийн инженер нь хяналтын үзлэгт хамрагдсан авто тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч нарт тухайн авто тээврийн хэрэгслийн техникийн байдлын талаар мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгааг өгөх,

10.Мотоцикл үзлэгт бүрэн хамруулах, бүртгэлжүүлэх арга хэмжээг аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагтай хамтран хэрэгжүүлэх,

11.Үзлэг оношилгоонд хамрагдсан тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг нэгдсэн сүлжээнд бүрэн хамруулах, ажлын явцын талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга сурталчлах, хангалтгүй хамрагдсан сум, байгууллагын зардлаар дахин зохион байгуулах.

12.Техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, бүртгэлийн зөрчилтэй, татвар, төлбөр, даатгал төлөөгүй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх талаар Цагдаагийн газар, Авто тээврийн төв хамтран холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 1/18 захирамжийн хоёрдугаар хавсралт



2023 ОНД ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙГ СУМДАД ХИЙХ АЖЛЫН ХЭСЭГ, ХУВААРЬ

№	д/д	Сумдын нэр	Хугацаа	Ажиллах өдөр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
		Булган сум	I / 01 - IY / 14		
I	1	Бугат	IY / 17 - IY / 19	3	(Ажлын хэсгийн ахлагч) - Автотээврийн төвийн дарга Ж.Батзориг (Ажлын хэсгийн гишүүд) - Техникийн хяналтын үзлэгийн инженер Х.Жавхлантөгс - Техникийн хяналтын үзлэгийн техникч Б.Батзориг - Тээвэр бүртгэлийн мэргэжилтэн А.Оюунгэрэл - Замын цагдаагийн тасаг - Тухайн сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг
	2	Сэлэнгэ	IY / 20 - IY / 22	3	
	3	Хялганат	IY / 23 - IY / 25	3	
	4	Хангал	IY / 26 - IY / 29	4	
II	5	Бүрэгхангай	Y / 01 - Y / 04	4	
	6	Баяннуур	Y / 05 - Y / 07	3	
	7	Дашинчилэн	Y / 08 - IY / 11	4	
	8	Рашаант	Y / 12 - Y / 15	4	
	9	Гурванбулаг	Y / 16 - Y / 19	4	
	10	Могод	Y / 20 - Y / 22	3	
	11	Хишиг-Өндөр	Y / 23 - Y / 26	4	
	12	Орхон	Y / 27 - Y / 30	4	
III	13	Сайхан	YI / 05 - YI / 07	3	
	14	Баян -Агт	YI / 08 - YI / 10	3	
	15	Хутаг -Өндөр	YI / 11 - YI / 17	7	
	16	Тэшиг	YI / 18 - YI / 21	4	
Нийт сумдад ажиллах өдөр				60	
	17.	Булган сум	YI / 26 - XII / 25		

---00000000---